

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2016.12.20.

Арвайхээр.

Тус цагдаагийн газар нь Цагдаагийн Ерөнхий Газраас 2016 онд дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн Ерөнхий Газрын даргын тушаалаар 2009 онд баталсан "Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт", "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам", холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагатай түншлэлийн холбоо тогтоож, хамтран ажиллах, алба хаагчдын сахилга ёс зүй, ажлын хариуцлага, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, ая тохитой орчинд ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нэг. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн

1.1. Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр:

2016 онд 560 өмнөх ажиллагаанд 632 эрүүгийн үйлдлийг мөрдөн байцаалтын ажиллагаанд 175 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорт шилжүүлж, 253 үйлдлийг үйлдүүлж, 94 хэргийг эрүүгийн хэрэгт нэгтгэн шалгаж, 5 хэргийг харъяаллын дагуу шилжүүлж, 71 үйлдлийг үйлдүүлж, 71 үйлдлийг үйлдүүлж, 71 үйлдлийг үйлдүүлж байна. Одоо ажиллагаанд үлдэгдэл 64 хэрэгтэй байна. Бүртгэгдэх үедээ сэжигтэнээр тооцогдвол зохих этгээд нь тогтоогдоогүй 233 эрүүгийн хэрэг бүртгэгдсэнээс 151 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба хэргийн илрүүлэлт 64,8 хувьтай байгааг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хэрэг бүртгэлтийн чиглэлээр бүртгэгдэх үедээ сэжигтэнээр тооцогдвол зохих этгээд нь тогтоогдоогүй 67 эрүүгийн хэрэг байснаас 45 буюу 67,2 хувийг нь илрүүлсэн. Мөрдөн байцаалтын шатанд гэмт хэргийн улмаас иргэд аж ахуйн нэгж байгууллагад нийт 672,8 сая төгрөгний хохирол учирсанаас 356,7 сая төгрөгний хохиролыг нөхөн төлүүлж 66,5 сая төгрөгний эд хөрөнгө битүүмжилсэн. Эхний 12 сарын байдлаар хэрэг бүртгэлтийн харьяаллын 202 гэмт хэрэгт 158 иргэн хөнгөн гэмтэл авч, иргэд байгууллагад 212,2 сая төгрөгний хохирол учирсанаас 176,7 сая төгрөгийг нөхөн төлүүлж, 121,1 сая төгрөгний хөрөнгө битүүмжилж, нийт хохирлын 883,3 %-ийг хэрэг бүртгэлтийн шатанд нөхөн төлүүлсэн байна. Урд оны мөн үетэй харьцуулахад нөхөн төлүүлэлт 9,5%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагч нар 251 холбогдогчтой, 445.0 сая төгрөгний хохиролтой, 182 материалаар 294 хэрэг, үйлдлийг илрүүлэн эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулахаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албанд шилжүүлэн ажилласан байна. Илрүүлсэн 294 хэрэг, үйлдлээс эзэн холбогдогч нь тогтоогдоогүй үндэслэлээр түдгэлзүүлсэн 51 хэргийг нөхөн илрүүлж ажилласан байна. 2016 онд мал хулгайлах гэмт хэргийн 46 гомдол мэдээлэлийг иргэд байгууллагаас хүлээн авч 28 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад гомдол мэдээлэл 15.2 хувиар, гэмт хэрэг 20 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

1.2. Нийгмийн хэв журам хамгаалах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Цагдаагийн газрын хэмжээнд нийгмийн хэв журам, хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн 8862 захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3 буюу 0.03 хувиар буурчээ. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, бусдын амгалан тайван байдал алдагдуулсан 1187 хүнийг саатуулж, 201 хүн баривчлан, 8144 хүнийг 352.6 сая төгрөгөөр торгож, 317 хүний авто машин жолоодох эрхийг хасаж ажилласан нь өмнөх оноос торгож, эрх хасагдсан жолооч 8 буюу 2.5 хувиар өссөн, баривчлагдсан хүн 126 буюу 30.2 хувиар буурсан, торгосон хүн 292 буюу 3.7 хувиар тус тус буурч, торгуулийн хэмжээ 254.1 сая төгрөгөөр буюу 2.5 дахин өссөн, саатуулагдсан хүн 322 буюу 37.2 %-аар өссөн үзүүлэлттэй байна. Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 52 гарч, урьд оны мөн үеэс 3 хэргээр буюу 5.4% буурсан, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 141 гарч 1.3 хувиар буурсан байна. Гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгуулахаар байгууллага, аж ахуйн нэгжид өгсөн албан даалгавар, мэдэгдэл 345-ыг өгч, 325 мэдэгдэл, шаардлагын хариуг хугацаанд нь

авч, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллаж байна. Алба хаагчдаас ЗХТХ-ийн 24 зүйлийг үндэслэн 135 нүүдэллэгчдийг үзлэг хийж 26 хутга мэд зодооны хэрэгсэл хурааж авч зохих журмын дагуу шийдвэрлэсэн байна.

1.3. Олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг өргөжүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр.

2016 оны 05, 10 дугаар сард зохион байгуулсан “Нээлттэй хаалга” өдөрлөгийн үеэр ОНЦХА-ны төвөөс эрхлэн гаргасан “Амар амгалан амьдралыг бид хамтдаа бүтээнэ”, “Иргэдийн эрх зүйн мэдлэгт”, “Олон нийт цагдаагийн хамтын ажиллагаа”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь бүх нийтийн үйлс”, “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор авлигын талаар мэдээлэх утас, авлигаас ангид байх” зэрэг санамж сэрэмжлүүлэг, зэрэг 15 төрлийн 850 ширхэг санамж, зөвлөмж, бэлтгэн иргэдэд тарааж, сурталчилсан байна. Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд аймгийн ГХУСАЗЗөвлөлтэй хамтран орон нутгийн үүрэн холбооны 2 оператор компаниар 2 төрлийн сэрэмжлүүлэгийг иргэд олон нийтэд түгээх ажлыг зохион байгууллаа. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагаар урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэгийг “Арвайхээр”, “Хас” телевизүүд, “Таны элч” сонин, “Өвөрхангай” сайт зэрэг нийт 89 удаа мэдээлэл боловсруулан иргэдэд сэрэмжлүүлэг, анхааруулгыг хүргэсэнээр сүүлийн үед хулгайн гэмт хэргийн гаралт 9.8 хувиар буурсан байна. Цагдаагийн газраас зохион байгуулж байгаа ажил үйлчилгээг иргэд, олон нийтэд хурдан шуурхай хүртээмжтэй хүргэх зорилгоор орон нутгийн Арвайхээр телевизтэй хамтран ажиллах гэрээ байгуулан газрын даргын 2016 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А\92 дугаартай тушаалаар “Ажлын хэсэг” байгуулж, хийгдэх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна. Гэрээ байгуулсан телевиз болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр олон нийт цагдаагийн хамтын ажиллагааны төвөөс эрхлэн гаргасан “Аргай”, “Шагай” хүүхэлдэйн дүрээр бүтээсэн шторкыг олон удаагийн давтамжтайгаар хүргэж, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэгийг сурталчилж байна.

Аймгийн Хууль зүйн хэлтсээс зарлагдсан “Архигүй орчин гэрэлт ирээдүй” 3 сарын аяны хүрээнд олон ажил зохион байгуулсаны дээр архины хамааралтай, арханд донтох өвчтэй иргэдтэй ажиллах үүрэг бүхий “Мэргэжлийн баг байгуулах” журмын төслийг гарган иргэд байгууллагаар хэлэлцүүлэн аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 06 сарын 09-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор батлуулж хэрэгжүүлэх ажил зохион байгуулж байна. Тус цагдаагийн газар нь “Архигүй орчин гэрэлт ирээдүй” 3 сарын аяны хүрээнд хэрэгжүүлсэн ажлаараа бусад байгууллагаа тэргүүлж өргөмжлөл 200.0 мянган төгрөгөөр шагнагдав. Сумдын цагдаагийн хэлтэс, тасаг, хэсэг, хэсгийн төлөөлөгч нарын дунд болзолт уралдаан зарлан дүгнэж тэргүүн байранд Бат-Өлзий сумын Цагдаагийн хэсэг, 2-р байранд Баян-Өндөр сум, 3-р байранд Сант сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа нар орж цалинг 10-20 % нэмж урамшуулав. АСТТХ, Архидалтгүй Өвөрхангай хөтөлбөр, хууль тогтоомжоор ХДТ, ШШГА, багийн ЭМТ-д тус тус сургалт явуулж, “Архигүй Баасан гариг” уриан дор 05 сарын 29-ны өдрөөс хойш аймгийн Дэлгэрэх ХХК-тай хамтран 6 удаагийн цэнгээнт бүжгийг “Баярын жавхаа” үлээвэр найрал хөгжмийн хамтлагтай зохион байгуулав. Согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газарт хэрэгжүүлэх “Үйлчилгээний чанарын талон”-ы загвар, журмын төслийг аймгийн тусгай зөвшөөрөл олгох орон тооны бус аймгийн зөвлөл”-өөр хэлэлцүүлэн шийдвэр гаргуулсан ба архины дуршлыг бууруулж эмчлэх 6 төрлийн эм бэлдмэлийн танилцуулгыг сумдын цагдаагийн нэгж, албан тушаалтнуудад хүргүүлэв.

Хоёр. Хүний нөөц, сургалт соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр хийсэн ажлын талаар:

2.1. Хүний нөөц, сургалт соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр

Орхон аймгийн газар үүсгэсэн төсөвт 180, гэрээт 4 ажилтан, Хархорин сум дахь сум дундын цагдаагийн хэлтэст эргүүлийн цагдаа 1, харуулын цагдаа 1, цагдаа-жолооч 1, төвд нярав цагдаа 1, Уянга сум дахь цагдаагийн хэсгийн цагдаа 1, Хайрхандулаан сумын цагдаа 1 орон дотроо ажилладаг.

Цагдаагийн газрын алба хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийн сайжруулах, ажил албанд нь сургаж дадлагажуулах, мэргэшүүлэх, хууль хэрэглэх чадварыг дээшлүүлэх зорилгоор энэ оны байдлаар 73 алба хаагчийг мэргэшүүлэх, давтан, эчнээ, магистрын, гүйцэтгэх ажлын чиглэлээр сургалтанд хамруулсан байна. Цагдаагийн байгууллагын түүхт 95 жилийн ой угтаж, Баянхонгор аймагт зохион байгуулагдсан “Хангайн бүсийн цагдаагийн газар”-ын алба хаагчдын дунд явагдсан “Урлаг спортын наадам”-д баг тамирчид бэлтгэж оролцон эрэгтэйчүүдийн гар бөмбөгийн тэмцээнд нэгдүгээр байр, сагсан бөмбөгийн тэмцээнд гуравдугаар

байр, гоцлол бүжгийн тэмцээнд нэгдүгээр байр, язгуур урлагийн тэмцээнд гуравдугаар байр тус тус эзэлсэн ба цагдаагийн газраас хийж гүйцэтгэж буй шинэлэг ажил, урлаг спортын арга хэжээнд оролцсон тухай 6 мэдээлэл бэлтгэж, “Цагдаа 95” буланд байршуулж иргэд олон нийтэд сурталчилж байна.

2016 оны 4, 10 дугаар сард зохион байгуулсан нэг, гуравдугаар улирлын сахилгын зөвлөгөөнөөс гарсан 4 чиглэлийн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2016 онд цагдаагийн газраас хийж гүйцэтгэж буй шинэлэг ажил, урлаг спортын арга хэжээнд оролцсон тухай 6 мэдээлэл бэлтгэж, “Цагдаа 95” буланд байршуулж иргэд олон нийтэд сурталчилж байна.

2.2. Алба хаагчдын хууль ёсны эрх, эрх ашгийг хамгаалах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр

Цагдаагийн газраас алба хаагчдыг сурч боловсрох нөхцөлийг хангаж, Хууль сахиулахын их сургуулийн эчнээ дамжаанд 8 алба хаагч, магистрийн сургалтанд 1 алба хаагч, Сургалтын төвөөс зохион байгуулсан давтан болон мэргэшүүлэх сургалтанд 25 алба хаагч, энхийг сахиулах ажиллагааны бэлтгэл сургалтанд 1 алба хаагчийг хамруулсан. Мөн өөрсдийн авьяас чадвараа дээшлүүлэх боломж олгож ЦЕГ аймаг орон нутгаас зохион байгуулагдсан урлаг спортын уралдаан тэмцээнд алба хаагчдыг тогтмол оролцуулж байгаагийн үр дүнд цагдаагийн дэслэгч Ц. Бээжин, цагдаагийн дэслэгч Э. Чойжил, цагдаагийн дэд ахлагч Б.Гансүх, цагдаагийн дэслэгч М.Доржготов, цагдаагийн ахлах дэслэгч Б. Мягмарсүрэн цагдаагийн ахлах ахлагч Б. Сангисүрэн нар ЦЕГ-ын аварга шалгаруулах самбо, жү-до, чөлөөт бөхийн тэмцээнээс удаа дараа мөнгө, хүрэл медаль Хангайн бүсийн цагдаагийн газруудын урлаг спортын наадмаас цагдаагийн дэд ахлагч Б.Ууганбаяр гоцлол бүжгийн төрөлд алт, цагдаагийн ахлагч Г. Чулуунбаяр язгуур урлагийн төрөлд хүрэл медаль хүртсэн байна. Эх үрсийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх талаар саналыг тасгуудаас авч төлөвлөгөө батлуулж, гэр бүл цагдаагийн газрын эмэгтэйчүүдийн дунд гар бөмбөгийн тэмцээн, хүүхэд багачуудын дунд 5 төрлийн тэмцээн уралдаан зохион байгуулж, шагнаж урамшуулав. Гэр бүлийн тэмцээний үеэр зөвлөгөөн хийж, байгууллагын гэр бүлийн зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй шинээр сонгов. Хужирт сумын цагдаагийн хэсгийн хамт олон өөрсдийн нөөц боломжийг ашиглан Зүүнбаянулаан сумын нутаг “Хүнгүй мухар” гэх газар 1 га талбайд хүнсний ногоо тариалж, 8 тонн ургац хураан авсан байна. Цагдаагийн газрын алба хаагчдаас 1 алба хаагч Тарагт сумын нутаг “Дайргын гол” гэх газар төмс тариалж 2 тонн ургац авсан бөгөөд ирэх онд энэ ажлыг өргөжүүлэх зорилт тавьж байна. Байгууллагын туслах аж ахуй хөгжүүлэх эхлэлийг тавьж 100 гаруй бог малтай болсон бөгөөд малчныг цалинжуулах эх үүсвэр байхгүй тул хамт олны дундын сангаас урамшуулал олгож байна. Цагдаагийн байгууллагын түүхт 95 жилийн ойг тохиолдуулан 7 ахмад настныг ОХУ-ын Буриад улсад, эрүүгийн тасгийн 13 алба хаагчийг Монгол улсын байгалийн үзэсгэлэнт Завхан, Хөвсгөл, Архангай аймгийн нутгаар, ЗЦТ-ийн алба хаагч нар Хөвсгөл Архангай аймгийн нутгаар, НХЖХТ-ийн 25 алба хаагч нарыг Уянга сумын нутаг “Найман нуур”, ТЗБ-ын тасгийн алба хаагч нарыг Батэлзий сумын “Орхоны хүрхрээ”-ийн чиглэлд тус тус аялуулсан байна.

2.3. Албан үүргээ гүйцэтгэж яваад амь үрэгдсэн алба хаагчид болон ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх чиглэлээр:

Сар шинийн баяраар ахмад настнуудад 900.0 мянган төгрөгний хүнсний зүйл, дурсгалын бэлэг гардуулсан байна. Ахмадын зөвлөлийн хурлыг энэ 03 дугаар сард цагдаагийн газарт хуралдуулсан ба энэ үеэр 14 ахмад настныг урьдчилан сэргийлэх эмнэлгийн үзлэгт хамруулав. Өвчний улмаас нас барсан 1 ахмад настны буяны ажилд дундын сангаас 100.0 мянган төгрөгний тусламж үзүүлэв. ЦЕГ-аас зохион байгуулсан “Ахмадуудын уулзалт зөвлөгөөн”-д байгууллагын ахмадын зөвлөлийн дарга бэлтгэл цагдаагийн ахмад О. Ванчиндоржийг оролцуулав. Цагдаагийн байгууллагын түүхт 95 жилийн ой угтаж хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу алба хаагчдыг албаараа бахархах, ахмад үеэсээ суралцуулах зорилгоор 04 дүгээр сард бэлтгэл цагдаагийн хошууч Г. Дамдинпүрэвтэй уулзалт ярилцлага зохион байгуулсан ба 05 дугаар сард бэлтгэл цагдаагийн ахлах ахлагч Д.Шийлэгбатын “Хөдөлмөрийн алдар”-ыг тэмдэглэх өдөрлөгийг зохион байгуулж алба хаагч нар идэвхтэй оролцов.

Дөрөв. Үйл ажиллагааны явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийг тайлагнах чиглэлээр авсан арга хэмжээ үр дүн.

Тус цагдаагийн газар нь 2015 оны үйл ажиллагааны тайланг Арвайхээр сумын иргэд, “Иргэний зөвлөл”-ийн гишүүдэд 2016 оны 01 дүгээр сарын 15-ний өдөр Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн “Иргэний танхим”-д тавьсан байна. Цагдаагийн газрын 2015 оны үйл ажиллагааны тайланг орон нутгийн хэвлэл “Таны илч” сонинд нийтэлж, хуралд оролцогчдод тараан өгөв. Бүх сумдын хэсгийн төлөөлөгч нарт тайлан хэвлэсэн “Таны илч” сонинг иргэдэд тараах сурталчлах зорилгоор хүргүүлсэн бөгөөд Хархорин Хужирт Уянга Батэлзий сумдын цагдаагийн хэлтэс, хэсгийн дарга нараас орон нутгийн иргэдэд тайлан тавьж холбогдох материал иргэдийн санал хүсэлтийг ирүүлсэн байна. Тайлангийн хуралд аймгийн Хууль зүйн хэлтсийн дарга, Арвайхээр сумын Засаг дарга, багийн дарга нар, “Иргэний зөвлөл”-ийн 6 гишүүн болон 300 орчим иргэд оролцсон бөгөөд хурлын үйл ажиллагааг орон нутгийн телевизүүдээр нэвтрүүлсэн ба байгууллагын веб сайтад тайланг байрлуулж иргэд олон нийтэд сурталчилав. Алба хаагчдын иргэдтэй харилцаж буй харилцааны соёлын түвшин, иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар байдал, үүрэг гүйцэтгэлтийн талаар дүгнэл гаргах зорилгоор “Түмний түүчээ” ТББ-гаар Цагдаагийн газрын хэрэглэгчийн үнэлгээг гаргах гэрээ байгуулж, гэрээний дагуу санал асуулгыг боловсруулж, Арвайхээр сумын 12 баг, Хужирт, Хархорин, Сант, Богд, Баян-Өндөр, Нарийнтээл сумын 500 иргэнээс судалгааг авч, тайланг гаргуулсан ба хэрэглэгчийн үнэлгээ **82.7%** буюу **“Сайн”** дүнтэй үнэлэгдсэн байна.

Тав. Шүүх, прокурорын мэдэгдэл, энгийн магадлалын дагуу авсан арга хэмжээ

Хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд илэрсэн зөрчлийг засуулах тухай аймгийн прокурорын газрын 15 шаардлагыг хүлээн авч зөрчлийг засах сургалтын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, буруутай алба хаагч нарт албаны шалгалт хийгдэж хариуцлага тооцож хариуг тухай бүр хүргүүлэв.

Зургаа. Цагдаагийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн тухай өргөдөл, мэдээлэл, санал хүсэлтийг шийдвэрлэж буй байдал.

2016 онд өдөж, аж ахуйн нэгж, агаарын тээврийн хэрэгсэл, агаарын тээврийн хэрэгсэл гэмт хэргийн шинжтэй 1109 агаарын тээврийн хэрэгсэл, 520 гомдол, мэдээлэлд үүсч, 572 агаарын тээврийн хэрэгсэл, 1109 агаарын тээврийн хэрэгсэл, 520 гомдол, мэдээллийг нэгтгэн шалгаж, 100% өргөдөлийг шийдвэрлэж байна. 49 гомдол, мэдээлэлтэй байна. 482 гомдол мэдээллийг 43,8%-ийг 5 өдөр, 614 гомдол, мэдээллийг 56,1%-ийг 5-19 хоногийн хугацаанд шийдвэрлэж байна. Гомдол мэдээллийн шийдвэрлэлт 98,8 хувьтай байна.

Энэ онд аймгийн “Шуурхай удирдлагын төв”-ийн 70321111 дугаарын утсанд цагдаагийн газар, алба хаагч нартай холбоотой 19 иргэнээс талархал, санал, гомдол мэдээлэл ирүүлсэн бөгөөд Засаг дарга тухай бүр танилцаж үүрэг чиглэл өгч биелэлтийг тооцсон болно. Цагдаагийн газрын алба хаагчтай холбоотой иргэд байгууллагаас гаргасан 8 мэдээлэл ирүүлсэний дагуу албаны шалгалт явуулахад 7 гомдол мэдээлэлд дурдсан асуудал нь тогтоогдоогүй 1 алба хаагчийн гаргасан зөрчлийг шалган тогтоож, уг алба хаагчид “Сануулах” сахилгын шийтгэл оногдуулсан байна. Засгийн газрын 1111 дугаарын утсанд 2 алба хаагчтай холбоотой гомдол ирснийг шалгаж гомдол гаргагчид хариу өгөв. Иргэний гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авах, албан тушаалтны нэр, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах, цагийн хуваарийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулсан байна.

Долоо. Санхүү, хангамжийн талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ

2016.12.15-ны өдрийн байдлаар улсын төсвөөс 1718269,3 мянган төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт авч, өөрийн орлогын төлөвлөгөө 54792,0 мянган төгрөг нийт 1773061,3 мянган төгрөг зарцуулах эрхтэй үүрэг гүйцэтгэснээс зардлын гүйцэтгэл 1747047,0 мянган төгрөг буюу 98,5 хувийн гүйцэтгэлтэй байна. 2016 онд хэмнэгдэх боломжтой зардлаас өглөг үүсээд байгаа зардалд Засгийн газрын 2013 оны 73 дугаар тогтоолын дагуу төсөвт зохицуулалт хийлгэх тухай 2 албан бичгийг зардлын судалгааны хамт ЦЕГ-ын Санхүү хангамжийн газарт хүргүүлж шийдвэрлүүлсэн. Сумдын хэсгийн төлөөлөгч нарын гэрэл цахилгаан, шатахууны зардалд лимит тогтоосон цагдаагийн газрын даргын тушаал гарган, тушаалыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2016 оны 11 дүгээр сарын байдлаар өөрийн орлогын төлөвлөгөө 8199,0 мянган төгрөг буюу 16,3 хувиар дутуу биелж байсан ба 2016 оны 12 дугаар сард тус цагдаагийн газраас галт зэвсэг эзэмшигч иргэдийн дунд сургалт зохион байгуулан 4,0 сая төгрөгийг төвлөрүүлээд байгаа бөгөөд оны эцэст өр авлага үүсгэхгүй ажиллах зорилт тавьж байна. Алба хаагч нарт 9900,0 мянган төгрөгийн торгуулийн тасалбар, 1226 ширхэг шийтгэвэр

олгож, 9280,0 мянган төгрөгийн торгуулийн тасалбар, 1102 ширхэг шийтгэврээр 119021,8 мянган төгрөг, нийт 128307,5 мянган төгрөгийн тооцоог хүлээн авч алба хаагчдын гар дээр 1895,0 мянган төгрөгний торгуулийн тасалбар, 214 ширхэг шийтгэвэрийн үлдэгдэлтэй байна. Бүтээлч ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлын шийдвэрээр байгууллага орчноо тохижуулах ажлыг тасаг албад хариуцан хийж дуусгав.

Найм. Цаашид хэрэгжүүлэх ажлын талаар.

1. Аймгийн хэмжээнд түдгэлзүүлсэн хэргийн нөхөн илрүүлэлтийн хувийг ахиулах зорилгоор нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг тооцох

2. Гэмт хэрэг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг хөрш зэргэлдээ аймгийн болон бүсийн Цагдаагийн газар, хэлтэстэй хамтран зохион байгуулах, хамтын ажиллагааг сайжруулж, эрэн сурвалжлах ажлын үр нөлөөг дээшлүүлэх

3. Сахилгын арга хэмжээ авагдсан алба хаагчийн тоо урьд оны түвшинд байгаа боловч таслан зогсоогдохгүй байгаад дүгнэлт хийж, алба хаагчдын сахилга, хариуцлага, удирдах болон ахлах ажилтнуудын шат дараалсан хяналтыг сайжруулж, манлайллыг дээшлүүлэх, сахилгын арга хэмжээг урьд оны мөн үеэс бууруулах

4. Хангайн бүсийн цагдаагийн газруудын алба хаагчдын дунд явагдах “Урлаг спортын наадам”, анхаарал татсан гэмт хэргүүдийг бууруулах чиглэлээр бүсчилсэн зөвлөгөөнийг санаачлан зохион байгуулах

ЦАГДААГИЙН ГАЗАР

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2016.12.20.

Арвайхээр.

Тус цагдаагийн газар нь Цагдаагийн Ерөнхий Газраас 2016 онд дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн Ерөнхий Газрын даргын тушаалаар 2009 онд баталсан "Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт", "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам", холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагатай түншлэлийн холбоо тогтоож, хамтран ажиллах, алба хаагчдын сахилга ёс зүй, ажлын хариуцлага, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, ая тохитой орчинд ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нэг. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн

1.1. Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр:

2016 оны жилийн эцсийн байдлаар 560 холбогдогчтой 632 эрүүгийн хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсанаас 175 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорт шилжүүлж, 253 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт хүргүүлж, 94 хэргийг эрүүгийн хэрэгт нэгтгэн шалгаж, 5 хэргийг харъяаллын дагуу шилжүүлж, 71 эрүүгийн хэргийг хууль зүйн үндэслэлээр нь түдгэлзүүлсэн байна. Одоо ажиллагаанд үлдэгдэл 64 хэрэгтэй байна. Бүртгэгдэх үедээ сэжигтэнээр тооцогдвол зохих этгээд нь тогтоогдоогүй 233 эрүүгийн хэрэг бүртгэгдсэнээс 151 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон ба хэргийн илрүүлэлт 64,8 хувьтай байгааг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хэрэг бүртгэлтийн чиглэлээр бүртгэгдэх үедээ сэжигтэнээр тооцогдвол зохих этгээд нь тогтоогдоогүй 67 эрүүгийн хэрэг байснаас 45 буюу 67,2 хувийг нь илрүүлсэн. Түдгэлзүүлсэн 25 эрүүгийн хэрэг байснаас 1 хэргийг нөхөн илрүүлж, ЭБШХ-ийн 24.1.1-ээр 1 хэрэг, 24.1.2-оор 13 хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэж, Сэргээсэн 3 хэргийг ажиллагаанд шалгаж байна. Одоо түдгэлзүүлсэн 7 хэргийн үлдэгдэлтэй байна. Мөрдөн байцаалтын чиглэлээр жилийн эцсийн байдлаар 107 түдгэлзүүлсэн эрүүгийн хэрэг байснаас шинээр нэмж 91 эрүүгийн хэрэг түдгэлзүүлсэн, 57 хэргийг нөхөн илрүүлж, 47 хэргийг хэрэгсэхгүй болгож, 11 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай шилжүүлж, 39 хэргийг нэгтгэсэн шийдвэрлэсэн. Сэргээсэн 4 хэргийг ажиллагаанд шалгаж байна. Одоо газрын хэмжээнд мөрдөн байцаалтын нийт 96 түдгэлзүүлсэн хэрэг үлдэгдлээр байгаагаас яллагдагч оргон зайлсан үндэслэлээр 1, шаардлагатай гэрч, хохирогч байхгүй үндэслэлээр 1, яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй үндэслэлээр 94 хэрэг байна. Мөрдөн байцаалтын шатанд гэмт хэргийн улмаас иргэд аж ахуйн нэгж байгууллагад нийт 672,8 сая төгрөгний хохирол учирсанаас 356,7 сая төгрөгний хохиролыг нөхөн төлүүлж 66,5 сая төгрөгний эд хөрөнгө битүүмжилсэн. Эхний 12 сарын байдлаар хэрэг бүртгэлтийн харьяаллын 202 гэмт хэрэгт 158 иргэн хөнгөн гэмтэл авч, иргэд байгууллагад 212,2 сая төгрөгний хохирол учирсанаас 176,7 сая төгрөгийг нөхөн төлүүлж, 121,1 сая төгрөгний хөрөнгө битүүмжилж, нийт хохирлын 883,3 %-ийг хэрэг бүртгэлтийн шатанд нөхөн төлүүлсэн байна. Урд оны мөн үетэй харьцуулахад нөхөн төлүүлэлт 9,5%-аар өссөн үзүүлэлттэй байна.

2016 онд мал хулгайлах гэмт хэргийн 46 гомдол мэдээлэлийг иргэд байгууллагаас хүлээн авч 28 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад гомдол мэдээлэл 15,2 хувиар, гэмт хэрэг 20 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх чиглэлээр 32 материалаар давхардсан тоогоор 63 холбогдогчтой, 101.000.000 /нэг зуун нэг сая төгрөг/ хохиролтой, 36 хэрэг үйлдлийг илрүүлэн гэмт хэргийн улмаас алдагдсан 247 малыг олж тогтоон ажиллалаа. Энэ онд урд оны дугаартай эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 205 дугаар зүйлийн 205.1.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн мал хулгайлах гэмт хэргээс эрүүгийн 201315010143, 2014.06000053, 201315010144, 2014150100008, 201615010026, 201315010064, 201315010031, 201515010073, 201415010105 дугаартай хэргүүдийг нөхөн илрүүлж ажилласан байна. Аймгийн хэмжээнд Арвайхээр сумаас бусад 18 суманд 95 малчины бүлэг нөхөрлөл, Тарагт, Нарийнтээл, Уянга, Зүүнбаян-Улаан, Хужирт, Бат-Өлзий, Баян-Өндөр, Өлзийт, Есөнзүйл, Бүрд сумдад 50 идэвхитэн малчин Арвайхээр суманд "Гүхийт хонгорын аргамжаа"

Хужирт суманд “Шунхлайн буянт мал сүрэг” нэртэй төрийн бус байгууллагууд малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж байна. Эдгээр малчидын бүлэг нөхөрлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэн ажиллах чиглэлээр тасаг, хэсэг, хэсгийн төлөөлөгч нарт зааварчилгаа хүргүүлэн ГХУССЗ-ийн гишүүдтэй хамтран ажиллалаа. Улаанбаатар хот, Арвайхээр сум руу хулгайн мал, мах орж ирж болзошгүй замд шалгалтыг зохион байгуулан гарал үүслийн гэрчилгээгүй мал мах тээвэрлэсэн зөрчилийг илрүүлэн 11 иргэнийг “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр 550.0 мянган төгрөгөөр торгосон байна. Хэсгийн төлөөлөгч, цагдаа нарыг үүрэгжүүлэн орон нутгийн замд шалгалтыг зохион байгуулуулж тээвэрлэж яваа мал, махыг гарал үүслийн гэрчилгээтэй тулгаж илэрсэн зөрчилийг арилгуулах шаардлагатай бол гомдол мэдээллээр шалган шийдвэрлүүлж ажиллалаа.

Оргодол эрэн сурвалжлах жагсаалтанд 2 мэдээлэл орж 2 мэдээллийн эрэн сурвалжлалтыг зогсоож эрэн сурвалжлах ажлын явц 100 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 100 хувиар өссөн, Гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд эрэн сурвалжлах жагсаалтанд 9 мэдээлэл орж 6 мэдээллийн эрэн сурвалжлалтыг зогсоож эрэн сурвалжлах ажлын явц 66.6 хувьтай байгаа өнгөрсөн оны мөн үеийнхээс 41.6 хувиар өссөн үзүүлэлттэй, оршин суугаа газраасаа алга болсон хүн эрэн сурвалжлах жагсаалтанд 6 мэдээлэл орж 2 мэдээллийн эрэн сурвалжлалтыг зогсоож эрэн сурвалжлах ажлын явц 33.3 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 16.7 хувиар буурсан байна. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас оргосон сэжигтэн, яллагдагчийг эрэн сурвалжилж олох ажлыг тасралтгүй зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. 2016 оны 1-р сард Тарагт сумын 4-р багийн иргэн М.Самбалдондовыг тус сумын харьяат Н.Адьяадорж нь зодож гэмтэл учруулан хэргийн газраас оргон зайлсныг 2016 оны 03-р сарын 02-ны өдөр Улаанбаатар хотоос хэсгийн төлөөлөгч, цагдаагийн хошууч А.Баттөгс баривчлан хариуцсан алба хаагчид хүлээлгэн өгсөн.

2. Эрүүгийн 201515000273 тоот хэргийн оргодол этгээд О.Дэмчигдоржийг 2016 оны 05 дугаар сарын 04-ний өдөр туслах төлөөлөгч, цагдаагийн ахлагч Ж.Мөнхжаргал Арвайхээр сумын 5-р багийн нутаг дэвсгэрээс баривчлан мөрдөн байцаах албанд хүлээлгэн өгсөн.

3. 2016 оны 03-р сарын 31-ний өдөр Арвайхээр сумын 8-р багийн иргэн Л.Баярсайханы байшинд хулгай орж эд зүйл хулгайд алдсан эрүүгийн 201615000136 тоот хэргийн оргодол С.Уртнасанг 2016 оны 06-р сарын 02-ны өдөр Арвайхээр сумын нутаг дэвсгэрээс эрүүгийн ахлах төлөөлөгч, цагдаагийн ахмад Д.Бат-Оргил баривчлан мөрдөн байцаах албанд хүлээлгэн өгсөн.

Одоо аймгийн хэмжээнд мөрдөн байцаах албанд шалгагдаж байгаад оргон зайлсан 1 оргодол, 2 гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдүүдийг эрэн сурвалжлан ажиллаж байна. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албанд 2006 оны 07 сарын 26-ны өдөр Бүрд сумын 4 дүгээр багийн нутагт Жумдаан нь Ц.Адьяажаргалын хэвлийн тус газар хайчаар хатгаж хүнд зэргийн гэмтэл учруулж танхайрсан гэмт хэрэг үйлдэж, батлан даалтанд өгөх таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан үедээ мөрдөн байцаалтын шатнаас оргон зайлсан гэх эрүүгийн 1 хэрэг байна.

1.2. Нийгмийн хэв журам хамгаалах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Цагдаагийн газрын хэмжээнд нийгмийн хэв журам, хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн 8862 захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3 буюу **0.03 хувиар буурчээ**. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, бусдын амгалан тайван байдал алдагдуулсан 1187 хүнийг саатуулж, 201 хүн баривчлан, 8144 хүнийг 352.6 сая төгрөгөөр торгож, 317 хүний авто машин жолоодох эрхийг хасаж ажилласан нь өмнөх оноос торгож, эрх хасагдсан жолооч 8 буюу 2.5 хувиар өссөн, баривчлагдсан хүн 126 буюу 30.2 хувиар буурсан, торгосон хүн 292 буюу 3.7 хувиар тус тус буурч, торгуулийн хэмжээ 254.1 сая төгрөгөөр буюу 2.5 дахин өссөн, саатуулагдсан хүн 322 буюу 37.2 %-аар өссөн үзүүлэлттэй байна. Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 52 гарч, урьд оны мөн үеэс 3 хэргээр буюу 5.4% буурсан, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 141 гарч 1.3 хувиар буурсан байна. Гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгуулахаар байгууллага, аж ахуйн нэгжид өгсөн албан даалгавар, мэдэгдэл 345-ыг өгч, 325 мэдэгдэл, шаардлагын хариуг хугацаанд нь авч, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллаж байна. Алба хаагчдаас ЗХТХ-ийн 24 зүйлийг үндэслэн 135 сэжигтэй этгээдэд үзлэг хийж 26 хутга мэс зодооны хэрэгсэл хурааж авч зохих журмын дагуу шийдвэрлэсэн байна.

Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгслэлийн эргэлтэд хяналт тавих тухай хууль тогтоомжийн дагуу Улаанбаатар хотоос Ховд аймгийн Дарви, Мөст, Баянхонгор аймгийн Галуут, Баяновоо, Баянөлгий аймаг уруу сумд руу хүнд даацын 87 автомашинаар 1388 тонн тэсэрэх бодис тээвэрлэн аймгийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх үеийн хамгаалалтад давхардсан тоогоор 174 алба хаагч ажиллан зөрчил дутагдалгүй дамжин өнгөрүүлсэн байна. Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “АСЕМ”-ын дээд

хэмжээний чуулган аймаг сумдын баяр наадам зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээ, баяр ёслолын болон төрийн тусгай хамгаалалтад нийт 60 удаа давхардсан тоогоор 731 алба хаагч 10200 цаг ажилласан байна. 2016 онд гудамж замд хяналт шалгалтаар 5024 зөрчил илрүүлж, шийтгэвэрээр 839 хүнд 62313,6 мянган төгрөгийн торгууль ногдуулж, бэлэн бус торгууль 3869 хүнд 237403,4 мянган төгрөгийн торгууль оногдуулж согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 316 зөрчлийг илрүүлж, 316 жолоочийн эрхийг 06 сараар хасч, торгож арга хэмжээ авав. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор аймгийн төрийн болон төрийн бус байгууллага, 5 аж ахуй нэгжийн 365 орчим хүнд сургалт зохион байгуулсан. Цагдаагийн газрын хэмжээнд бэлэн бус торгуулийн “Police reader” 6 ширхэг багажийг албан хэрэгцээнд ашиглаж Арвайхээр, Уянга, Хархорин, Хужирт сумуудад гарсан 747 зөрчилд 24.7 сая төгрөгийн торгууль оногдуулсан байна. Аймгийн Мэдээлэл шуурхай удирдлагын төвөөс Арвайхээр сумын хяналтын камераар замын хөдөлгөөний хууль дүрэм зөрчиж хөдөлгөөнд оролцож байгаа зөрчлийг илрүүлэн бүртгэн авч, 256 зөрчил гаргагч нарыг илрүүлж арга хэмжээг тооцож, дахин зөрчил гаргуулахгүй байх талаар сануулж ажиллалаа. Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сумын Засаг дарга болон аймгийн иргэдийн хурлын даргаар батлуулсан төлөвлөгөөг гаргуулан хэрэгжүүлж ажилласан бөгөөд урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хот хоорондын хяналт шалгалт”, “Мотоцикл”, “Баг”, “Иргэн таны төлөө”, “Нийтийн тээвэр”, “Хөдөлгөөнт эргүүл” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцов. Мөн Богд, Баруунбаян-Улаан сумын жолооч нарын дунд сургалт, уран жолоодлогын тэмцээн, сургууль цэцрлэгийн хүүхдүүдийн дунд “Ногоон гэрэл цагаан шугам” тэмцээнийг зохион байгуулсан. “Зам тээврийн ослоор хохирогсод хүндэтгэл үзүүлэх дэлхий нийтийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлж иргэдэд хор хохирлын талаар сэрэмжлүүлсэн. Аймгийн төвийн гэрэлтүүлэг гэрлэн дохио ямар нэгэн эвдрэлгүй хэвийн ажиллаж байгаа бөгөөд замын зохион байгуулалтын чиглэлээр тэмдэг, тэмдэглэлийн үзлэг тооллого хийж шаардлагатай тэмдэгийн судалгааг гаргаж холбогдох байгууллагаар 16 газар тэмдэг тавиулсан. Аймгийн хэмжээнд 2016 онд шинээр гүйцэтгэсэн зам байхгүй хуучин замд нөхөөс болон давхар хучилт хийх ажил Арвайхээр сумын төвд тавигдсан бөгөөд замын тэмдэг, тэмдэглэл 24 хурд сааруулагч 6, гарц 8, гэрлэн дохио 1 тус тус шинээр хийлгүүлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулсан болно.

1.3. Олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг өргөжүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 257 дугаар тогтоолоор батлагдсан “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 13 заалт бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2016 оны 12 сарын 15-ны байдлаар төлөвлөгөөний 20 заалт хэрэгжиж, 8 заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.



2016 оны 05, 10 дугаар сард зохион байгуулсан “Нээлттэй хаалга” өдөрлөгийн үеэр ОНЦХА-ны төвөөс эрхлэн гаргасан “Амар амгалан амьдралыг бид хамтдаа бүтээнэ”, “Иргэдийн эрх зүйн мэдлэгт”, “Олон нийт цагдаагийн хамтын ажиллагаа”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь бүх нийтийн үйлс”, “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор авлигын талаар мэдээлэх утас, авлигаас ангид байх” зэрэг санамж сэрэмжлүүлэг, зэрэг 15 төрлийн 850 ширхэг санамж, зөвлөмж, бэлтгэн иргэдэд тарааж,

сурталчилсан байна. “Нээлттэй хаалга” өдөрлөгийн арга хэмжээнд цагдаагийн газрын бие бүрэлдэхүүн, аймгийн Засаг даргын тамгын газрын дарга, иргэний зөвлөлийн гишүүд, ЕБС-ын сурагчид, Авто жолооны курсын сургуулийн багш, суралцагчид, Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газрын дэргэдэх “Таеквондо”-ийн “Шонхор” клубын тамирчид, “Баярын жавхаа” үлээвэр найрал хөгжмийн сурагчид, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Арвайхээр сумын иргэн-олон нийтийн зөвлөл болон Арвайхээр сумын 11 багийн иргэд оролцлоо. Олон нийт цагдаагийн хамтын ажиллагааны хүрээнд авч байгаа санал, асуулгыг нийт өдөрлөгийн арга хэмжээнд оролцсон 300 гаруй иргэнээс авч дүгнэв. Өдөрлөгийн үйл ажиллагааг орон нутгийн “Арвайхээр”, “Соёмбо”, “GM” телевиз, “Таны элч”, “Өвөрхангайн өнгө” сэтгүүлээр иргэд, олон нийтэд сурталчилж ажиллав. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Цагдаагийн албаны тухай хууль, тогтоомжийг цагдаагийн газрын фэйсбүүк, цахим хаягаар 1 удаа, орон нутгийн “Арвайхээр”, “Хас” телевизээр 2 удаа, “Таны-элч” сонинд 1 удаа нийтэлж, нийт 4 удаа иргэд олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулан ажилласаны үр дүнд иргэд “Олон нийтийн цагдаагийн ажилтан”, “Иргэний зөвлөл”-ийн талаарх мэдлэг нь сайжирч, тэдний хийж гүйцэтгэж байгаа ажлыг ойлгох, хамтын ажиллагаа сайжирсан. Мөн иргэд, жолооч нарт Хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, Захиргааны хариуцлагын тухай хуулийн холбогдох заалтуудаар болон жолооны эрх сэргээх, үнэмлэх нөхөн авах, зөрчлийн оноо, галт зэвсгийн бүртгэл, үнэмлэх олгох талаар болон “Амар амгалан амьдралыг бид хамтдаа бүтээнэ”, “Иргэдийн эрх зүйн мэдлэгт”, “Олон нийт цагдаагийн хамтын ажиллагаа”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь бүх нийтийн үйлс” зэрэг 15 төрлийн 850 ширхэг санамж, зөвлөмж, бэлтгэн 150 гаруй иргэдэд зөвлөгөө өгч, тарааж, хүрэлцэн ирсэн иргэдээс 5 санал, 12 хүсэлт, 5 талархалыг хүлээн авч, ирүүлсэн санал хүсэлтийг газар дээр нь шийдвэрлэж, 3 саналыг холбогдох байгууллагад уламжлан хүргүүлсэнээр иргэн, цагдаагийн байгууллагын уялдаа холбоо өргөжиж байна. Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх жилийн хүрээнд “Хулгай хар мөртэй” сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг ЕБС, МСҮТ-ийн сурагчдын дунд 2 насны ангиллаар зохион явуулахаар удирдамж боловсруулж, хүргүүлж, хэрэгжилтэнд хяналт тавьж байна. Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд аймгийн ГХУСАЗЗөвлөлтэй хамтран орон нутгийн үүрэн холбооны 2 оператор компаниар 2 төрлийн сэрэмжлүүлэгийг иргэд олон нийтэд түгээх ажлыг зохион байгууллаа. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагаар урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэгийг “Арвайхээр”, “Хас” телевизүүд, “Таны элч” сонин, “Өвөрхангай” сайт зэрэг нийт 89 удаа мэдээлэл боловсруулан иргэдэд сэрэмжлүүлэг, анхааруулгыг хүргэсэнээр сүүлийн үед хулгайн гэмт хэргийн гаралт 9.8 хувиар буурсан байна. Цагдаагийн газраас зохион байгуулж байгаа ажил үйлчилгээг иргэд, олон нийтэд хурдан шуурхай хүртээмжтэй хүргэх зорилгоор орон нутгийн Арвайхээр телевизтэй хамтран ажиллах гэрээ байгуулан газрын даргын 2016 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А192 дугаартай тушаалаар “Ажлын хэсэг” байгуулж, хийгдэх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Гэрээ байгуулсан телевиз болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр олон нийт цагдаагийн хамтын ажиллагааны төвөөс эрхлэн гаргасан “Аргай”, “Шагай” хүүхэлдэйн дүрээр бүтээсэн шторкыг олон удаагийн давтамжтайгаар хүргэж, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэгийг сурталчилж байна. Орон нутгийн замд гарч буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Оюутан тээвэр”, “Мотоцикль-5,6,7,8”, “Согтуу” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээг 8 удаа, Багуудын нутаг дэвсгэрт гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нийгмийн дэг журмыг хангахад иргэд байгууллагыг татан ороцуулж, иргэдэд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль” болон бусад хууль тогтоомжийг сурталчилан таниулах, олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийн цагдаа болон багийн иргэний зөвлөлийн гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдэд аюулгүй амар тайван орчинг бүрдүүлэх зорилгоор “Хөрш айл-4,5,6”, “Эзэнгүй айл-1,2” гэх мэт нийт 5 удаагийн хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг үр дүнтэй зохион байгуулсаны үр дүнд гэмт хэргийн гаралт 2016 онд 6.2 хувиар буурсан эерэг үзүүлэлтэй байна. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, бусдын амгалан тайван байдал алдагдуулсан 1193 хүнийг албадан саатуулж, 202 хүн баривчлан, 7940 хүнийг 349.9 сая төгрөгөөр торгож, 305 хүний авто машин жолоодох эрхийг хасаж ажилласан ба согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 141 гарч урд оны мөн үеэс 2 буюу **1.3 %-аар буурсан** байна.

Аймгийн Хууль зүйн хэлтсээс зарлагдсан “Архигүй орчин гэрэлт ирээдүй” 3 сарын аяны хүрээнд олон ажил зохион байгуулсаны дээр архины хамааралтай, арханд донтох өвчтэй иргэдтэй ажиллах үүрэг бүхий “Мэргэжлийн баг байгуулах” журмын төслийг гарган иргэд байгууллагаар хэлэлцүүлэн аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 06 сарын 09-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор батлуулж хэрэгжүүлэх ажил зохион байгуулж байна. Мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд архинд донтох өвчтэй иргэдийг бүртгэн эмнэлэгийн дүгнэлт гаргуулах, сайн дурын болон албадан эмчилгээнд хамруулах, АА-гийн бүлэгтэй

хамтран ажиллаж элсүүлэх ажил хэрэгжүүлж байна. Одоогийн байдлаар 146 хүнд архинд донтох өвчтэй гэсэн дүгнэлт гаргуулан ажиллаж байна. Тус цагдаагийн газар нь “Архигүй орчин гэрэлт ирээдүй” 3 сарын аяны хүрээнд хэрэгжүүлсэн ажлаараа бусад байгууллагаа тэргүүлж өргөмжлөл 200.0 мянган төгрөгөөр шагнагдав. Сумдын цагдаагийн хэлтэс, тасаг, хэсэг, хэсгийн төлөөлөгч нарын дунд болзолт уралдаан зарлан дүгнэж тэргүүн байранд Бат-Өлзий сумын Цагдаагийн хэсэг, 2-р байранд Баян-Өндөр сум, 3-р байранд Сант сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа нар орж цалинг 10-20 % нэмж урамшуулав. АСТТХ, Архидалтгүй Өвөрхангай хөтөлбөр, хууль тогтоомжоор ХДТ, ШШГА, багийн ЭМТ-д тус тус сургалт явуулж, “Архигүй Баасан гариг” уриан дор 05 сарын 29-ны өдрөөс хойш аймгийн Дэлгэрэх ХХК-тай хамтран 6 удаагийн цэнгээнт бүжгийг “Баярын жавхаа” үлээвэр найрал хөгжмийн хамтлагтай зохион байгуулав. Согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газарт хэрэгжүүлэх “Үйлчилгээний чанарын талон”-ы загвар, журмын төслийг аймгийн тусгай зөвшөөрөл олгох орон тооны бус аймгийн зөвлөл”-өөр хэлэлцүүлэн шийдвэр гаргуулсан ба архины дуршлыг бууруулж эмчлэх 6 төрлийн эм бэлдмэлийн танилцуулгыг сумдын цагдаагийн нэгж, албан тушаалтнуудад хүргүүлэв. Архидан согтууралтай тэмцэх чиглэлээр энэ улиралд “Зөвшөөрөл”, “Баасан гараг”, “Шалгалт” зэрэг тусгай арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тооцов. Аймгийн хэмжээний согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг 461 цэгт үйл ажиллагаа явуулж байгаа ба аймгийн Хууль зүйн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Татварын хэлтэстэй хамтарсан шалгалтыг тусгай удирдамжийн дагуу явуулж дүнг “Аймгийн тусгай зөвшөөрлийн орон тооны бус зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлэн 7 дэлгүүрийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 45 тусгай зөвшөөрөлтэй цэгийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэн, 166 цэгт камержуулалт, гэрэлтүүлгийг сайжруулах чиглэлээр хугацаатай албан мэдэгдлийг хүргүүлээ. Хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаа тухай бүр аймгийн Соёмбо, Арвайхээр, Хас телевизээр мэдээлэв. Зөвшөөрөлгүй согтууруулах ундаа худалдан борлуулж байсан 7 зөрчлийг илрүүлэн 9,25 литр архи, 35,9 литр пиво хураан авч улсын орлого болгуулахаар аймгийн Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлэн хариуцлага тооцов.

Хоёр. Хүний нөөц, сургалт соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр хийсэн ажлын талаар:

2.1. Хүний нөөц, сургалт соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр

Цагдаагийн газар нь 160 төсөвт 180, гэрээт 4 агаар баага аааааааа, Хархорин сум дахь сум дундын цагдаагийн хэлтэст эргүүлийн цагдаа 1, харуулын цагдаа 1, цагдаа-жолооч 1, төвд нярав цагдаа 1, Уянга сум дахь цагдаагийн хэсгийн цагдаа 1, Хайрхандулаан сумын цагдаа 1 орон дий аааааа аааааа.

Хүний нөөцийн нөхөн хангалтыг ХСИС-ийн Цагдаагийн сургууль төгссөн сонсогчид болон бусад их, дээд сургууль төгссөн иргэдийг төрийн тусгай алба хаагчдын сул орон тоог өрсөлдүүлэн шалгаруулж нөхөх журмын дагуу судлан, мэргэшлийн шалгалтад хамруулан тэнцсэн иргэдийг цагдаагийн мэргэжлийн сургалтын төвд сургалтанд хамруулан сул орон тоонд томилуулах ажлыг зохион байгуулж ажилласан.

Төрийн тусгай албан тушаалын сул орон тоог нөхөх ажлын байрны захиалгыг ЦЕГ-ын Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлж, цагдаагийн байгууллагад ажиллахыг хүссэн 45 иргэнийг эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн гэсэн эмнэлэгийн байгууллагын дүгнэлт гарснаас хойш хэсгийн байцаагч, эрүүгийн төлөөлөгч, сэтгэл зүйч нарын хамт судалгааны ажлыг зохион байгуулан удирдлагад танилцуулж, шаардлага хангасан 27 иргэнийг судлан төрийн тусгай албан хаагчдын сонгон шалгаруулалтанд оруулж, шалгалтанд тэнцсэн 10 албан хаагчийг албан тушаалд томилон, 2016 оны 11 дүгээр сард зохион байгуулагдсан сонгон шалгаруулалтанд 12 иргэнийг хамруулж, шалгалтанд тэнцсэн 7 иргэнийг Төрийн албаны салбар зөвлөлийн дэргэдэх ЦЕГ-ын салбар зөвлөлийн нөөцөд бүртгүүлж, 4 алба хаагчийг албан тушаалд томилон, 2 алба хаагчийг цагдаагийн анхан шатны дамжаанд хамруулж, 1 алба хаагч нөөцөд бүртгэгдэж, ХСИС-ийн Цагдаагийн сургууль төгссөн 6 иргэнийг Бүрд, Баяруунбаян-Улаан, Зүүнбаян-Улаан, Гучин-Ус сумдын хэсгийн төлөөлөгчөөр, 2 алба хаагчийг мөрдөн байцаагчаар тус тус томилуулан ажиллаж байна.

Цагдаагийн газрын алба хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийн сайжруулах, ажил албанд нь сургаж дадлагажуулах, мэргэшүүлэх, хууль хэрэглэх чадварыг дээшлүүлэх зорилгоор энэ оны байдлаар 73 алба хаагчийг мэргэшүүлэх, давтан, эчнээ, магистрын, гүйцэтгэх ажлын чиглэлээр сургалтанд хамруулсан байна.

Цагдаагийн байгууллагын түүхт 95 жилийн ойг тохиолдуулан аймгийн чөлөөт хэвлэл болох “Өвөрхангайн өнгө” сэтгүүлийн ажилтнуудтай хамтран цагдаагийн газрын 2012-2016 онд хийж гүйцэтгэсэн онцлог үйл явдлыг тусгасан тусгай дугаарыг хэвлүүлэхэд бэлэн болгов. Цагдаа олон нийтийн хамтын ажиллагааны төвд музейд тавих үзмэр болон “Цагдаагийн гавьяа”, “Цагдаагийн алдар” тэмдэгтэй хүмүүс үе үеийн удирдах ажилтнуудын судалгааг хүргүүлэв. Цагдаагийн байгууллагын түүхт 95 жилийн ой угтаж, Баянхонгор аймагт зохион байгуулагдсан “Хангайн бүсийн цагдаагийн газар”-ын алба хаагчдын дунд

явагдсан “Урлаг спортын наадам”-д баг тамирчид бэлтгэж оролцон эрэгтэйчүүдийн гар бөмбөгийн тэмцээнд нэгдүгээр байр, сагсан бөмбөгийн тэмцээнд гуравдугаар байр, гоцлол бүжгийн тэмцээнд нэгдүгээр байр, язгуур урлагийн тэмцээнд гуравдугаар байр тус тус эзэлсэн ба цагдаагийн газраас хийж гүйцэтгэж буй шинэлэг ажил, урлаг спортын арга хэжээнд оролцсон тухай 6 мэдээлэл бэлтгэж, “Цагдаа 95” буланд байршуулж иргэд олон нийтэд сурталчилж байна.



Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн “Ой тэмдэглэн өнгөрүүлэх тухай” б/374 дүгээр тушаалаар Цагдаагийн байгууллагын түүхт 95 жилийн ой, “Цагдаагийн алба хаагчдын тэмдэглэлт өдөр”-ийг тэмдэглэх, иргэд олон нийтэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилах зорилгоор ёслолын арга хэмжээг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 11 цагт аймгийн Аюуш баатарын талбайд зохион байгуулав. Энэ үеэр Цагдаагийн байгууллагын 95 жилийн ойг тохиолдуулан нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажилд идэвхи санаачлагатай, үр бүтээлтэй ажилласан 43 алба хаагчдад ЦЕГ-ын “Албаны төлөө” 1, 2 3 дугаар зэргийн медаль, Аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын “Хүндэт жуух” бичгээр шагнагдсан цагдаагийн ахмад Ч. Отгонжаргал, цагдаагийн ахлах дэслэгч Б. Алтанцацрал, цагдаагийн ахлагч Ч. Цэрэннадмид нарт Хууль зүйн хэлтсийн дарга Ц.Пунцаг, цагдаагийн дэд хурандаа Г. Чимэддагва нар шагналыг гардуулав. Шагнагдсан алба хаагчдад СТА, цагдаагийн дэд хурандаа Р.Амаржаргалын удирдсан Цагдаагийн газрын дэргэдэх “Баярын жавхаа” үлээвэр найрал хөгжмийн хамтлаг алба хаагчдад баяр хүргэж мэндчилгээ дэвшүүлэв. Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Д.Алтангэрэл дасгалжуулагчтай “Шонхор” клубын баг тамирчид “Гардан тулаан”-ы үзүүлэх тоглолт иргэд олон нийтэд сонирхуулав. Ёслолын жагсаалын үеэр цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, түүхэн замнал, алба хаагчдыг алдаршуулан сурталчилсан мэдээ, мэдээллийг аймгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилла.

2016 оны 4, 10 дугаар сард зохион байгуулсан нэг, гуравдугаар улирлын сахилгын зөвлөгөөнөөс гарсан 4 чиглэлийн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2016 онд цагдаагийн алба хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан зөрчлийн хэлбэр, хэм хэмжээг харгалзан шат дараалсан сахилгын шийтгэл оногдуулах зарчим баримтлан нийт 30 алба хаагчид сахилгын шийтгэл оногдуулснаас 1 алба хаагчид ЦЕГ-ын даргын, 1 алба хаагчид ЭЦГ-ын даргын, 5 алба хаагчид хэлтсийн даргын, 23 алба хаагчид байгууллагын даргын тушаалаар сахилгын шийтгэл оногдуулсан байна. Урьд онд нийт 29 алба хаагч сахилгын арга хэмжээ авагдснаас офицер 18, ахлагч 11 байсан бол 2016 оны байдлаар 30 алба хаагч сахилгын арга хэмжээ авагдснаас офицер 19 ахлагч 11 байгаа сахилгын зөрчил 1-ээр буюу 3,4 хувиар өссөн байна. Сахилгын зөрчлийн өнгөөр авч үзвэл согтууруулах ундаа хэрэглэсэн зөрчил 10, ажлын хариуцлага алдсан зөрчил 4, харилцааны соёл, ёс зүй зөрчсөн 3, ЭБШ хууль тогтоомж зөрчсөн 8, үүрэг даалгавар үл биелүүлсэн 1, цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм зөрчсөн 1, бусад зөрчил гаргасан 3 алба хаагч байна. 2016 оны 3 дугаар улирлын байдлаар эрүүгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Бямбасүрэн, саатуулах байрны жижүүрийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Б.Гансүх, Өлзийт сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Ц.Хад-Оргодол нар эрүүгийн гэмт хэрэгт холбогдон шалгагдаж, Баруунбаян-Улаан сумын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Ж.Отгонбаатар эрүүгийн гэмт хэрэгт өртөж хохирсон байна. Цагдаагийн газрын үйл ажиллагаа, алба хаагчидын сахилга хариуцлагын талаарх мэдээллийг Цагдаагийн газрын вэб сайтад байрлуулж, алба хаагчид болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гомдол мэдээллийг Засаг даргын дэргэдэх Шуурхай удирдлагын төвийн 70321111, цагдаагийн газрын 7032102, 70322691 тоот утсаар хүлээн авч ажиллаж байгаа бөгөөд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг түргэн шуурхай иргэдэд хүртээмжтэй байлгах, цагдаагийн байгууллагын аюулгүй байдлыг хангах зорилгоор өдрийн дуудлагын цагдааг хөтөч цагдаагийн үүргийг давхар гүйцэтгүүлэн ажиллаж байна. “Харилцааны соёлыг дээшлүүлэх дэд хөтөлбөр”-ийн хүрээнд зохион байгуулагдсан “Нэг үхрийн эвэр дорговол мянган үхрийн эвэр доргино” сэдэвт илтгэлийн

уралдаанд ирүүлсэн илтгэлийг 1-3 дугаар байр эзлүүлж, шалгарсан илтгэлийг цалингийн 5-15 хүртэл хувиар шагнуулсан ба илтгэлийг 1 дүгээр улиралын сахилгын зөвлөгөөний үеэр байр эзэлсэн алба хаагчид өөрсдөө уншиж танилцуулж, өргөмжлөлийг гардуулав. Хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Ч.Амартүвшин нь ЦЕГ-ын даргын 869 тушаалаар батлагдсан “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”-ийн 12.12 дахь заасан бусадтай зүй бус хүндэтгэлгүй харилцсан зөрчил дутагдал гаргасан тул иргэнтэй зөв боловсон харилцах талаар зөвлөмж өгөв. Сант сумын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Д.Ганхүлэг нь архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн учир архи уухгүй байх талаар алба хаагчдын сахилгын зөвлөгөөн дээр үүрэг амлалт авахуулж, “Итгэл найдвар”-ын хуудас гардуулж өгсөн.

“Харилцах урлаг” гарын авлага, стрессээс урьдчилан сэргийлэх, ядаргаа тайлах ая, бичлэг, дасгал зэрэг 8 мэдээлэл Цагдаагийн газрын хаалттай бүлгэмд нийтэлсэн. Сумдын цагдаа, хэсгийн төлөөлөгч нарын цугларалтаар “Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёлыг дээшлүүлэх” дэд хөтөлбөрөөр 2 удаа сургалт зохион байгуулав. Цагдаагийн газрын санал хүсэлтийн хайрцагт ирүүлсэн 16 санал асуулгын хуудсыг дүнг нэгтгэн удирдлагад танилцуулан сарын бүрийн “Тэргүүний ёс зүйтэй алба хаагч”-аар шалгарах болзол хангасан алба хаагчийн талаар нийт 46 алба хаагчаас санал авч 2016 оны 03, 04 дүгээр сарын “Тэргүүний ёс зүйтэй алба хаагч”-аар, 2 алба хаагчийг тодруулан Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар оруулан цалингийн 10 хувиар шагнаж урамшуулахаар шийдвэрлүүлж урамшуулсан байна. Архидан согтуурах явдалтай тэмцэх ахлах байцаагч цагдаагийн дэд хурандаа Р. Амаржаргал нийт алба хаагч нарт архидан согтуурлын хор уршгийн талаар 2 удаа сургалт зохион байгуулж баталгаа бичгээр авсан бөгөөд байгууллага дээр “Архидалтгүй Өвөрхангай хөтөлбөр”-ийн нэрэмжит туг дэвтэр аялуулав. Удаа дараа согтууруулах ундаа хэрэглэсэн, ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн 1 офицерийг албанаас дутагдлаар халав. Шинээр томилогдож ирсэн 15 алба хаагчдад албандаа түргэн дасан зохицох, иргэнтэй хэрхэн зөв боловсон харилцах, биеэ зөв авч явах талаар зөвлөмж өгч, алба хаагч бүртэй “Хариуцлагын гэрээ” байгуулж цагдаагийн алба хаагчийн сахилга ёс зүйн дүрмийг зөрчихгүй, авилга ашиг сонирхлын зөрчилд холбогдохгүй ажиллах талаар баталгаа авч хэвшсэн байна.

2.2. Алба хаагчдын хууль ёсны эрх, эрх ашгийг хамгаалах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр

Цагдаагийн газраас алба хаагчдыг сурч боловсрох нөхцөлийг хангаж, Хууль сахиулахын их сургуулийн эчнээ дамжаанд 8 алба хаагч, магистрийн сургалтанд 1 алба хаагч, Сургалтын төвөөс зохион байгуулсан давтан болон мэргэшүүлэх сургалтанд 25 алба хаагч, энхийг сахиулах ажиллагааны бэлтгэл сургалтанд 1 алба хаагчийг хамруулсан. Мөн өөрсдийн авьяас чадвараа дээшлүүлэх боломж олгож ЦЕГ аймаг орон нутгаас зохион байгуулагдсан урлаг спортын уралдаан тэмцээнд алба хаагчдыг тогтмол оролцуулж байгаагийн үр дүнд цагдаагийн дэслэгч Ц. Бээжин, цагдаагийн дэслэгч Э. Чойжил, цагдаагийн дэд ахлагч Б.Гансүх, цагдаагийн дэслэгч М.Доржготов, цагдаагийн ахлах дэслэгч Б. Мягмарсүрэн цагдаагийн ахлах ахлагч Б. Сангисүрэн нар ЦЕГ-ын аварга шалгаруулах самбо, жү-до, чөлөөт бөхийн тэмцээнээс удаа дараа мөнгө, хүрэл медаль Хангайн бүсийн цагдаагийн газруудын урлаг спортын наадмаас цагдаагийн дэд ахлагч Б.Ууганбаяр гоцлол бүжгийн төрөлд алт, цагдаагийн ахлагч Г. Чулуунбаяр язгуур урлагийн төрөлд хүрэл медаль хүртсэн байна.



Эх үрсийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх талаар саналыг тасгуудаас авч төлөвлөгөө батлуулж, гэр бүл цагдаагийн газрын эмэгтэйчүүдийн дунд гар бөмбөгийн тэмцээн, хүүхэд багачуудын дунд 5 төрлийн тэмцээн уралдаан зохион байгуулж, шагнаж урамшуулав. Гэр бүлийн тэмцээний үеэр зөвлөгөөн хийж, байгууллагын

гэр бүлийн зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй шинээр сонгов. Хүүхдийн эрхийг хамгаалах Олон улсын өдөр, эх үрсийн баярт хүрэлцэн ирсэн хүүхэд бүрийг чихэртэй таргаар дайлж, 16-аас доош насны 190 хүүхдүүдэд бэлэг гардуулсан ба бэлэгний үнэнд Цагдаагийн газрын дундын сангаас 950,0 мянган төгрөг, алба хаагчдын цалингаас 950.0 мянган төгрөг зарцуулсан.



ЦЕГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу 2016 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн Онгийн голын Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн “Цэргийн амралт”-ын газар алба хаагчид, гэр бүл үр хүүхдийн хамт амрав. Өдөрлөгийн үеэр алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, стрессийг тайлах зорилгоор цагдаагийн газрын “Үндэсний бөх”-ийн аварга шалгаруулах барилдааныг Төлөвлөлт зохион байгуулалтын тасаг зохион байгуулж, Сант сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Ц.Бээжин түрүүлж, өргөмжлөл, мөнгөн шагнал, алтан медалиар, саатуулах байрны цагдаа, цагдаагийн дэд ахлагч А.Ганзориг үзүүрлэж мөнгөн медаль өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдав. “Хэн сайн айраг уух вэ?” хөгжөөнт тэмцээнийг Хэрэг бүртгэх мөрдөн байцаах тасаг зохион байгуулж эрэгтэй оролцогчдоос тэргүүн байрыг Замын цагдаагийн зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Ч.Балжинням, дэд байрыг Эрүүгийн цагдаагийн тасгийн туслах төлөөлөгч, цагдаагийн ахлах ахлагч Ж.Мөнхжаргал, эмэгтэй оролцогчдоос тэргүүн байрыг Замын цагдаагийн тасгийн алба хаагчийн гэр бүл Т.Оюун, дэд байрыг Эрүүгийн цагдаагийн тасгийн гэр бүл Б.Нямсүрэн нар эзэлсэн байна. Хөл бөмбөгийн тэмцээнийг Замын цагдаагийн тасаг зохион байгуулж, тэргүүн байрыг Эрүүгийн цагдаагийн тасгийн баг тамирчид, дэд байрыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн 2 дугаар багийн тамирчид, гутгаар байрыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн 1 дүгээр багийн тамирчид тус тус эзэлж дурсгалын зүйлээр шагнагдсан. Алба хаагчид болон ар гэрийнхэний дунд азын 20 гаруй нэр төрлийн аяны хэрэгслийн сугалаа сугалуулж, азтангуудыг тодруулсан бөгөөд супер азтанаар ХБ, МБТ-ийн дарга цагдаагийн дэд хурандаа Л. Мөнхбаатар тодорч аяны майхнаар шагнуулав. Цагдаагийн байгууллагын түүхт 95 жилийн ойг тохиолдуулан 7 ахмад настныг ОХУ-ын Буриад улсад, 13 алба хаагчийг Монгол улсын байгалийн үзэсгэлэнт газруудаар, НХЖХТ-ийн 25 алба хаагч нарыг Уянга сумын нутаг “Найман нуур”, ТЗБ-ын тасгийн алба хаагч нарыг Батөлзий сумын “Орхоны хүрхрээ”-ийн чиглэлд тус тус аялуулсан байна.

2.3. Албан үүргээ гүйцэтгэж яваад амь үрэгдсэн алба хаагчид болон ахмад настуудад хүндэтгэл үзүүлэх чиглэлээр:

Сар шинийн баяраар ахмад настуудад 900.0 мянган төгрөгний хүнсний зүйл, дурсгалын бэлэг гардуулсан байна. Ахмадын зөвлөлийн хурлыг энэ 03 дугаар сард цагдаагийн газарт хуралдуулсан ба энэ үеэр 14 ахмад настныг урьдчилан сэргийлэх эмнэлгийн үзлэгт хамруулав. Өвчний улмаас нас барсан 1 ахмад настны буяны ажилд дундын сангаас 100.0 мянган төгрөгний тусламж үзүүлэв. ЦЕГ-аас зохион байгуулсан “Ахмадуудын уулзалт зөвлөгөөн”-д байгууллагын ахмадын зөвлөлийн дарга бэлтгэл цагдаагийн ахмад О. Ванчиндоржийг оролцуулав. Цагдаагийн байгууллагын түүхт 95 жилийн ой угтаж хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу алба хаагчдыг албаараа бахархах, ахмад үеэсээ суралцуулах зорилгоор 04 дүгээр сард бэлтгэл цагдаагийн хошууч Г. Дамдинпүрэвтэй уулзалт ярилцлага зохион байгуулсан ба 05 дугаар сард бэлтгэл цагдаагийн ахлах ахлагч Д.Шийлэгбатын “Хөдөлмөрийн алдар”-ыг тэмдэглэх өдөрлөгийг зохион байгуулж алба хаагч нар идэвхтэй оролцов.



“Ахмадын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан газрын даргаар батлуулж төлөвлөгөөний дагуу 2016 оны 10 дугаар сарын 03-ны өдөр байгууллагын ахмад настнуудын зөвлөлтэй хамтран Цагдаагийн газарт 23 ахмадыг урьж газрын дарга ахмад настнуудын санал хүсэлтийг хүлээн авч, ЦЕГ-ын ахмадын байгууллагын 95 жилийн ойн тэмдэг, үнэмлэх, түүхийн номыг гардуулан өгөв. Өшгөг ресторанд ахмад настнуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн бөгөөд энэ арга хэмжээнд нийт 401,800 төгрөг зарцуулсан байна. Цагдаагийн газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу албан үүргээ гүйцэтгэж яваад амь үрэгдсэн алба хаагчдын гэр бүлд хүндэтгэл үзүүлэх, хүнд өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон цагдаагийн бэлтгэл хошууч Д.Гаваад иж бүрэн 5 ханатай шалтай гэр хашааг хүлээлгэн өгөх үйл ажиллагааг хөтөлбөр төлөвлөгөөний дагуу 2016 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр амжилттай зохион явууллаа.



Албан үүргээ гүйцэтгэж яваад амь үрэгдсэн цагдаагийн ахлах ахлагч Д.Гантулга, цагдаагийн ахлагч Д.Пүрэвсүрэн, цагдаагийн дэд ахлагч Ц. Буянжаргал нарын гэр бүлийн төлөөллийг Цагдаагийн газрын даргын өрөөнд Цагдаагийн газрын дэргэдэх зөвлөлийн гишүүд хүлээн авч хүндэтгэл үзүүлж, санал хүсэлтийг хүлээн авсан байна.



Албан үүргээ гүйцэтгэж яваад амь үрэгдсэн алба хаагчдын гэр бүл Арвайхээр сумын 10 дугаар баг 41-

ийн 4 тоотод оршин суугч С. Дуламсүрэн, Арвайхээр сумын 4 дүгээр багийн 23-ын 13 тоотод оршин суугч Б. Соронзонболд, Арвайхээр сумын 1 дүгээр багийн 15 дугаар гудамж 5 тоотод оршин суугч Б. Сосорбурам нарт тус бүр “Дурсамж” 30000 төгрөг, мөн 10 шуудай нүүрсийг гардуулж өгсөн ба аймгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр иргэд олон нийтэд сурталчлав.



Мөн өдөр Баруунбаянулаан суманд хэсгийн төлөөлөгчөөр ажиллаж байхдаа 2006 онд тархинд нь цус харваж, хөгжлийн бэрхшээлтэй болсон ахмад настан цагдаагийн бэлтгэл хошууч Д.Гаваад иж бүрэн 5 ханатай давхар бүрээстэй шалтай, тавилгатай гэр, шинэ хашааг хүлээлгэн өгөх үйл ажиллагааг Арвайхээр сумын шинэ 12 дугаар багийн 24 дүгээр гудамж 14 тоот хашаанд зохион байгуулав.



Арга хэмжээнд Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүн, ахмад настанууд, Арвайхээр сумын Засаг дарга, Баруун Баян-Улаан сумын Засаг дарга болон бэлтгэл хошууч Д.Гаваа түүний төрөл төрөгсөд бусад иргэд оролцсон.



Хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчдөд Цагдаагийн газрын ЗЦТ-ийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч Б.Энхболд, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Г.Эрдэнэбат нар СТА, цагдаагийн дэд хурандаа Р.Амаржаргалын ая, цагдаагийн ахлах ахлагч Б.Ёндонжамцын үг “Энхийн манаа”, “Төрийн цагдаа”, мөн аймгийн теарын дуучин Н.Соёл уртын дуугаар ая дууны мэндчилгээ дэвшүүлсэн.



Бэлтгэл хошууч Д.Гаваагийн амьдралд 5 ханатай давхар бүрээстэй шалтай гэр, хашаа бэлдэж өгөх ажилд чин сэтгэлээсээ оролцож хамтран ажилласан Арвайхээр, Баруунбаян улаан сумдын Засаг дарга нарт “Дурсамж”, “Цагдаагийн газрын түүхэн товчоон-2” ном, эрхэлсэн ажилдаа амжилт гаргаж, хамт олноо хошуучилсан Замын цагдаагийн тасгийн цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Б.Батнасанд “Албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан алба хаагчид”-ын нэрэмжит шагналыг Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа Я.Ганбат гардуулав.



Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа Я.Ганбат ахмад настан, бэлтгэл хошууч Д. Гаваад иж бүрэн гэр хашааг түлхүүрийн хамт гардуулж өгөв. Гэр хашаа хүлээн авсан ахмад настан Д. Гаваагийн гэр бүлд зориулж, “Уяхан замбуу тивийн наран” уртын дуугаар хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Ч.Амартүвшин, шинэ гэрийн ерөөлөөр цагдаа жолооч, цагдаагийн ахлагч О.Дашням нар мэндчилгээ дэвшүүлэв.



“Бид мартахгүй” сэдэвт сайн үйлсийн аян, өдөрлөгийн арга хэмжээг Арвайхээр сумын Соёмбо, ЖИ ЭМ телевизээр нэвтрүүлж иргэд олон нийтэд сурталчилсан болно.



Хүнд өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон бөгөөд өөрийн гэсэн гэр оронгүй цагдаагийн бэлтгэл хошууч Д.Гаваад иж бүрэн 5 ханатай шалтай, тавилгатай гэр хашааг хүлээлгэн өгөх арга хэмжээнд алба хаагчдаас тус бүр 10000 төгрөгний сайн дурын хандив, Арвайхээр сумын Засаг дарга засмал зам, худагт ойр хашааны газар, Баруунбаян улаан сумын Засаг дарга хашаа барих банз бусад материалын үнийг хандивласан байна.

2.4. Нийгэм олон нийтээс талархал хүлээх, дэмжлэг туслалцаа авах

2016 оны 03 дугаар сард Замын цагдаагийн тасгаас санаачлан цагдаагийн газрын нийт алба хаагчдын дунд "Байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалья" сэдэвт өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулж, Арвайн талд байрлах "Хурдан морины их шүтэн"-ий ойролцоо газрыг элдэв хог хаягдал архи пивоны шилнээс цэвэрлэж хаягдал түүхий эдэд тушаасан орлогоор гурил будаа авч, амьдралын бэрхшээлтэй айлын хүүхдүүдэд гардуулав. Замын цагдаагийн газраас санаачилсан цас зудтай байгаа аймгуудын малчдад хандив тусламж өгөх 1 сарын аяны үйл ажиллагаанд алба хаагч нар идэвхтэй оролцож 80 боодол буюу 640.0 мянган төгрөгний ногоон өвсийг хаваржилт хүндэрсэн Баянөндөр сумын малчдад 04 дүгээр сард гардуулж өгөв.



Байгаль орчны газраас төрийн байгууллагуудын алба хаагчдын дунд зохион байгуулсан "Дэвжээ" тэмцээнд алба хаагчид оролцож тэргүүн байр, "Залуучуудыг дэмжих жил"-ийн ажлын хүрээнд Арвайхээр сумаас зохион байгуулсан "Урлаг спортын бага наадам"-д алба хаагчид амжилттай оролцож гар бөмбөгийн болон урлагийн төрлөөр тэргүүн, дэд байр тус тус эзлэв. Эдгээр арга хэмжээг тухай бүр бүр орон нутгийн телевизээр нэвтрүүлж, сэтгүүл, сонинд нийтлүүлж иргэд олон нийтэд сурталчилсан байна.





Архидалтгүй Өвөрхангай хөтөлбөрийн хүрээнд архины хамааралтай, архинд донтох өвчтэй иргэдтэй ажиллах, эмчлүүлэх чиглэлээр цагдаагийн газраас санаачлага гарган дараах шинэлэг ажил, арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, АА-гийн бүлэгтэй хамтран хэрэгжүүлж эхлээд байна. Дээрх ажлыг системтэй, цэгцтэй зохион байгуулах үүднээс “Мэргэжлийн баг” байгуулж ажиллах нь илүү үр дүнтэй гэсэн санал гарган холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран аймгийн “Иргэний танхим”-д 05 сарын 18-нд хэлэлцүүлэг зохион байгуулсаны үр дүнд санал дэмжлэг авч улмаар мэргэжлийн баг ажиллах журмын төсөл боловсруулан аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар 06 сарын 09-ны өдөр хэлэлцүүлэн 100 % саналаар батлагдсан болно. /Тогтоолын хуулбарыг хавсаргав/. Согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газарт хэрэгжүүлэх “Үйлчилгээний чанарын талон”-ы загвар, журмын төслийг аймгийн тусгай зөвшөөрөл олгох орон тооны бус аймгийн зөвлөл”-өөр хэлэлцүүлэн шийдвэр гаргуулсан ба архины дуршлыг бууруулж эмчлэх 6 төрлийн эм бэлдмэлийн танилцуулгыг сумдын цагдаагийн нэгж, албан тушаалтнуудад хүргүүлэв.



Гурав. УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газар, ЦЕГ -ын даргын болон аймгийн өөрөө удирдах байгууллага Засаг даргын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүн.

Тайлангийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тогтоол, эрх зүйн бичиг баримт, ЦЕГ-ын дарга, дэд дарга нарын өгсөн үүрэг даалгавар, тушаал, шийдвэрийг бие бүрэлдэхүүнд танилцуулж, үр дүнгийн гэрээнд тусгуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулав. Монгол Улсын Засгийн газраас гаргасан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой үүрэг, даалгавар, шийдвэрүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”, “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх”, “Хүн худалдаалах, хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас урьдчилан сэргийлэх” зэрэг үндэсний хөтөлбөрүүд, болон тушаал шийдвэр албан даалгавруудыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган биелэлтийг тооцон ЦЕГ-ын ТЗБ-ын хэлтсээс ирүүлсэн тушаал шийдвэрийн биелэлт гаргах хуваарийн дагуу холбогдох газар, хэлтэс рүү хугацаанд нь хүргүүлж ажиллав. Мөн Өвөрхангай аймгийг 2012-2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн засаг даргын “Бүтээлч Өвөрхангай” мөрийн хөтөлбөрийн биелэлтүүдийг гаргаж аймгийн хууль зүйн хэлтсийн даргын нэр дээр 12 дугаар сарын 20-ны дотор хүргүүлэв. ЦЕГ-ын даргын “Удирдах ажилтны зөвлөгөөн” дээр өгсөн үүрэг ажлын чиглэл, ЦЕГ-ын тэргүүн дэд дарга, ЦЕГ-ын дэд даргын албан даалгавар үүрэг чиглэлүүдийн заалт бүрийг ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, биелэлтийг тооцон ЦЕГ-ын ТЗБХ, Хуулийн хэлтэс, Хүний нөөц сургалтын хэлтэс, Дотоод хяналт шалгалт аюулгүй байдлын газарт тус тус хугацаанд нь хүргүүлэв. ЦЕГ болон түүний албад, бусад байгууллагуудад өссөн дүнгээр 3977 албан бичиг, тоотыг хүргүүлж, бусад газраас Цагдаагийн газарт ирүүлсэн 3053 албан бичгийг хүлээн авч, 537 хариуг хугацаанд нь хүргүүлж 196 албан бичгийн хугацаа дуусаагүй байна. ЦЕГ-ын

даргын зөвлөлийн шийдвэрийг тухай бүр бие бүрэлдэхүүнд танилцуулж, цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу 20 удаа хийж, цагдаагийн газрын даргын 239 тушаал гаргаж холбогдох асуудлыг шийдвэрлэв

Дөрөв. Үйл ажиллагааны явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийг тайлагнах чиглэлээр авсан арга хэмжээ үр дүн.

Тус цагдаагийн газар нь 2015 оны үйл ажиллагааны тайланг Арвайхээр сумын иргэд, “Иргэний зөвлөл”-ийн гишүүдэд 2016 оны 01 дүгээр сарын 15-ний өдөр Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн “Иргэний танхим”-д таьсан байна. Цагдаагийн газрын 2015 оны үйл ажиллагааны тайланг орон нутгийн хэвлэл “Таны илч” сонинд нийтэлж, хуралд оролцогчдод тараан өгөв. Бүх сумдын хэсгийн төлөөлөгч нарт тайлан хэвлэсэн “Таны илч” сонинг иргэдэд тараах сурталчлах зорилгоор хүргүүлсэн бөгөөд Хархорин Хужирт Уянга Батэлзий сумдын цагдаагийн хэлтэс, хэсгийн дарга нараас орон нутгийн иргэдэд тайлан тавьж холбогдох материал иргэдийн санал хүсэлтийг ирүүлсэн байна. Тайлангийн хуралд аймгийн Хууль зүйн хэлтсийн дарга, Арвайхээр сумын Засаг дарга, багийн дарга нар, “Иргэний зөвлөл”-ийн 6 гишүүн болон 300 орчим иргэд оролцсон бөгөөд хурлын үйл ажиллагааг орон нутгийн телевизүүдээр нэвтрүүлсэн ба байгууллагын веб сайтад тайланг байрлуулж иргэд олон нийтэд сурталчилав. Энэ онд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой газрын даргын А тушаал 65, Б тушаал 47 батлагдан гарч тухай бүр алба хаагч нарт танилцуулж байсан бөгөөд төсөв санхүүгийн чиглэлээрх 8 тушаалыг “Шилэн данс”-ны нэгдсэн системд байрлуулсан. 2016 оны 01 дүгээр сард ЦЕГ-ын даргын тушаалаар томилогдсон “Удирдах ажилтны үйл ажиллагааны үр дүн, мэргэжил, ур чадварын түвшин тогтоох шалгалт”-ын ажлын хэсгийнхэн удирдах ажилтнуудыг удирдамжийн дагуу бие бялдрын түвшин, эрх зүйн мэдлэг, ажлын үр дүнгийн чиглэлээр шалгаж үнэлэлт дүгнэлт өгсөн ба нийт алба хаагчдаас удирдах ажилтнуудын манлайлал харилцааны соёл, ажил хэрэгч байдал, алба хаагчдыг ялгаварлан гадуурхахгүй байх талаар санал асуулга авсан болно.

Тав. Шүүх, прокурорын мэдэгдэл, энгийн магадлалын дагуу авсан арга хэмжээ

Хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд илэрсэн зөрчлийг засуулах тухай аймгийн прокурорын газрын 2016 оны 03 дүгээр сарын 28-ны өдрийн 02, Замын цагдаагийн тасгийн зохицуулагч нарт явуулсан шалгалтаар илэрсэн зөрчлийн арилгуулах тухай 03 дугаар сарын 28-ны өдрийн 01 тоот, Хархорин сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагаанд шалгалтаар илэрсэн зөрчлийг засуулах тухай Хархорин сум дахь сум дундын прокурорын газрын 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 5/05, хяналтаар илэрсэн зөрчлийг засуулах тухай 03 дугаар сарын 31-ний өдрийн 5/04 дүгээр шаардлага, 06 дугаар сарын 23-ны өдрийн “Илэрсэн зөрчлийг засуулах тухай” 04, “Илэрсэн зөрчлийг засуулж хариуцлага тооцуулах тухай” 08 дугаар сарын 19-ний өдрийн 06, “Илэрсэн зөрчлийг арилгуулах тухай” 08 дугаар сарын 19-ний өдрийн 7/07 дугаар шаардлага зэрэг 15 прокурорын шаардлагыг хүлээн авч зөрчлийг засах сургалтын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, буруутай алба хаагч нарт албаны шалгалт хийгдэж хариуцлага тооцож хариуг тухай бүр хүргүүлэв.

Зургаа. Цагдаагийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн тухай өргөдөл, мэдээлэл, санал хүсэлтийг шийдвэрлэж буй байдал.

2016 оны эхний 12 сард иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас гэмт хэргийн шинжтэй 1109 гомдол, мэдээллийг хүлээн авч 520 гомдол, мэдээлэлд нь эрүүгийн хэрэг үүсгэн, 572 гомдол, мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал прокурорт хүргүүлж, эрүүгийн хэрэгт 4 гомдол, мэдээллийг нэгтгэн шалгаж, бүх гомдол мэдээллийг 100% хуулийн хугацаанд нь шалгаж, гомдол мэдээлэл гаргагчид хариуг нь өгч, одоо үлдэгдэл 49 гомдол, мэдээлэлтэй байна. Нийт хүлээн авсан гомдол, мэдээллийн 482 гомдол мэдээллийг буюу 43,8 %-ийг нь 5 хоногт, 614 гомдол, мэдээллийг буюу 56,1 %-ийг нь 5-19 хоногийн хугацаанд шалгаж шийдвэрлэсэн байна. Гомдол мэдээллийн шийдвэрлэлт 98,8 хувьтай байна. Хугацаа хэтрүүлэн шалгасан гомдол мэдээлэл байхгүй. Иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн явц байдлыг 7 хоног тутмын 1 дэх өдөр бие бүрэлдэхүүнд танилцуулж, мэдээлэл хийн, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар холбогдох үүрэг чиглэлийг өгч хэвшээд байна. Энэ хугацаанд аймгийн прокурорын газрын ажилтнууд цагдаагийн газрын хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч нарын өргөдөл гомдлыг шийдвэрлэх чиглэлээр хамтарсан зөвлөгөөнийг сар бүр хийж ажлын явц байдал, гарч буй зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр хамтран ажилласны үр дүнд хэргийн илрүүлэлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлт сайжирч байна.

Энэ онд аймгийн “Шуурхай удирдлагын төв”-ийн 70321111 дугаарын утсанд цагдаагийн газар, алба хаагч нартай холбоотой 19 иргэнээс талархал, санал, гомдол мэдээлэл ирүүлсэн бөгөөд Засаг дарга тухай бүр танилцаж үүрэг чиглэл өгч биелэлтийг тооцсон болно. Цагдаагийн газрын алба хаагчтай холбоотой иргэд байгууллагаас гаргасан 8 мэдээлэл ирүүлсэний дагуу албаны шалгалт явуулахад 7 гомдол мэдээлэлд

дурдсан асуудал нь тогтоогдоогүй 1 алба хаагчийн гаргасан зөрчлийг шалган тогтоож, уг алба хаагчид "Сануулах" сахилгын шийтгэл оногдуулсан байна. Засгийн газрын 1111 дугаарын утсанд 2 алба хаагчтай холбоотой гомдол ирснийг шалгаж гомдол гаргагчид хариу өгөв. Иргэний гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авах, албан тушаалтны нэр, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах, цагийн хуваарийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулсан байна.

Долоо. Санхүү, хангамжийн талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ

2016.12.15-ны өдрийн байдлаар улсын төсвөөс 1718269,3 мянган төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт авч, өөрийн орлогын төлөвлөгөө 54792,0 мянган төгрөг нийт 1773061,3 мянган төгрөг зарцуулах эрхтэй үүрэг гүйцэтгэснээс зардлын гүйцэтгэл 1747047,0 мянган төгрөг буюу 98,5 хувийн гүйцэтгэлтэй байна. 2016 онд хэмнэгдэх боломжтой зардлаас өглөг үүсээд байгаа зардалд Засгийн газрын 2013 оны 73 дугаар тогтоолын дагуу төсөвт зохицуулалт хийлгэх тухай 2 албан бичгийг зардлын судалгааны хамт ЦЕГ-ын Санхүү хангамжийн газарт хүргүүлж шийдвэрлүүлсэн. Сумдын хэсгийн төлөөлөгч нарын гэрэл цахилгаан, шатахууны зардалд лимит тогтоосон цагдаагийн газрын даргын тушаал гарган, тушаалыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2016 оны 11 дүгээр сарын байдлаар өөрийн орлогын төлөвлөгөө 8199,0 мянган төгрөг буюу 16,3 хувиар дутуу биелж байсан ба 2016 оны 12 дугаар сард тус цагдаагийн газраас галт зэвсэг эзэмшигч иргэдийн дунд сургалт зохион байгуулан 4,0 сая төгрөгийг төвлөрүүлээд байгаа бөгөөд оны эцэст өр авлага үүсгэхгүй ажиллах зорилт тавьж байна. Төсвийн хөрөнгийн захиран зарцуулалтын талаар алба хаагч нарт зориулсан мэдээллийн самбар ажиллуулж, 7 хоног бүрийн даваа гаригт санхүүгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хийж хэвшсэн бөгөөд сар бүр байгууллагын веб сайт, Шилэн дансны нэгдсэн системд байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг оруулж олон нийтэд танилцуулж байна. Мөн хэсгийн төлөөлөгч, цагдаа нар, сумдын цагдаагийн хэсэг тасгийн алба хаагч нарт цагдаагийн газрын санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг албан бичгээр хүргүүлж танилцуулж байна. Алба хаагч нарт 9900,0 мянган төгрөгийн торгуулийн тасалбар, 1226 ширхэг шийтгэвэр олгож, 9280,0 мянган төгрөгийн торгуулийн тасалбар, 1102 ширхэг шийтгэвэрээр 119021,8 мянган төгрөг, нийт 128307,5 мянган төгрөгийн тооцоог хүлээн авч алба хаагчдын гар дээр 1895,0 мянган төгрөгний торгуулийн тасалбар, 214 ширхэг шийтгэвэрийн үлдэгдэлтэй байна. Торгуулийн хуудас, шийтгэврийн ашиглалтанд тавих хяналтыг сайжруулж ЦЕГ-ын даргын 2010 оны 641 дүгээр тушаалаар батлагдсан "Шийтгэвэр, торгуулийн хуудас зэрэг тооцооны хуудсаар хангах, хадгалах, олгох, зарцуулах, тооцох бүртгэх" журмыг хэрэгжүүлэх зорилгоор хэсгийн төлөөлөгч, хэсгийн цагдаа нарын цугларалтанд нийт 4 удаа 6 цагийн сургалт орсон. Бүтээлч ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлын шийдвэрээр байгууллага орчноо тохижуулах ажлыг тасаг албад хариуцан хийж дуусгав.



Эрүүгийн цагдаагийн тасгийн хамт олон хурлын заалыг иж бүрэн тохижуулав



Замын цагдаагийн тасгаас замын цагдаагийн байр, Онгийн гол дахь замын цагдаагийн постын байр, цагдаагийн газрын гадна зам талбайг тохижуулав.




Цагдаагийн газрын гадна пассад, газрын даргын өрөөг Улаанбаатар хотын “Мэргэд групп” ХХК-аар засварлаж тохижуулав.



ТЗБ-ын тасгаас цагдаагийн газрын гадна орчныг засаж тохижуулав.



НХЖХТ-аас цагдаагийн газрын байрны нэг хоёрдугаар давхарыг засаж тохижуулав.



ХБ, МБТ-аас байцаалтын өрөөнүүдийг засаж тохижуулав.

2016 оны 07 дугаар сарын 05 хүртэл хугацаанд цагдаагийн газрын алба хаагчдын өрөө тасалгаа тохижуулах болзолт уралдаан зарлаж конторт болон кобан байранд сууж үйл ажиллагаа явуулдаг алба хаагч нар өөрсдийн санаачилга зардлаар өрөөний хаалгаа сольж, засварлан тохижуулсан байна.

Найм. Цаашид хэрэгжүүлэх ажлын талаар.

1. Аймгийн хэмжээнд түдгэлзүүлсэн хэргийн нөхөн илрүүлэлтийн хувийг ахиулах зорилгоор нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг тооцох

2. Гэмт хэрэг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг хөрш зэргэлдээ аймгийн болон бүсийн Цагдаагийн газар, хэлтэстэй хамтран зохион байгуулах, хамтын ажиллагааг сайжруулж, эрэн сурвалжлах ажлын үр нөлөөг дээшлүүлэх

3. Сахилгын арга хэмжээ авагдсан алба хаагчийн тоо урьд оны түвшинд байгаа боловч таслан зогсоогдохгүй байгаад дүгнэлт хийж, алба хаагчдын сахилга, хариуцлага, удирдах болон ахлах ажилтнуудын шат дараалсан хяналтыг сайжруулж, манлайллыг дээшлүүлэх, сахилгын арга хэмжээг урьд оны мөн үеэс бууруулах

4. Хангайн бүсийн цагдаагийн газруудын алба хаагчдын дунд явагдах “Урлаг спортын наадам”, анхаарал татсан гэмт хэргүүдийг бууруулах чиглэлээр бүсчилсэн зөвлөгөөнийг санаачлан зохион байгуулах

**ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН : ТЗБ-ЫН ТАСГИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА**

Д.ЭРДЭНЭБАТ

**ХЯНАСАН: ДАРГА, ЦАГДААГИЙН ДЭД
ХУРАНДАА**

Я.ГАНБАТ